

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 03 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 14 цаг 15 минутад эхэлж, мөн өдрийн 19 цаг 15 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 5 цаг 00 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах тухай.	2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдөр, амжихгүй бол 7 хоногоор сунгаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлж батлахаар болов.
2	Аймгийн хэмжээнд 2021 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний төсөл хэлэлцүүлэх тухай	Аймгийн хэмжээнд 2021 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний төсөл хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
3	“Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” ОНӨААТҮГ-ыг байгуулах дүрмийн төсөл хэлэлцүүлэх тухай	“Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” ОНӨААТҮГ-ыг байгуулах дүрмийн төсөл хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүхэд үүрэг болгов.
4	“Шинэ Ховд - Жаргалант ТҮК” ОНӨААТҮГ байгуулах дүрмийн төсөл хэлэлцүүлэх тухай	“Шинэ Ховд - Жаргалант ТҮК” ОНӨААТҮГ байгуулах дүрмийн төсөл хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүхэд үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР